

Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт /2022 оны хагас жил/

2022 оны 05 дугаар сарын 18

Бодь

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилто т түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
1. Нэг: “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээнд:							
1		1.1.1. Сумын нутаг дэвсгэрт коронавирусийн халдварын цар тахалтай тэмцэх, хүн амыг “Ковид-19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, салбар дундын зохицуулалт, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангана.	2021 - 2024			Ковид-19 вирусийн халдвараас сэргийлэх ажлын төлөвлөгөөг гарган шаардлагатай бэлэн байдлыг жагсаалтаар гарган нөөц бэлдэн ажиллаж байна.	70%
2	1.1. “Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлнэ.	1.1.2. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон үед эрүүл мэндийн салбарын хэмжээний шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, оношлуур халдваргүйжүүлэх бодис, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг тасралтгүй, хомсдол үүсэхээс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, нөөцийг бүрдүүлнэ.	2021 - 2024			Зайлшгүй шаардлагатай эм эмнэлэгийн хэрэгсэлийн жагсаалтыг гарган нөөцийг бүрдүүлсэн	70%
3		1.1.3. Цахим орчин, албан байгууллага, багийн Засаг дарга нараар дамжуулан, иргэдэд коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөө, зөвлөмжийг хүргэх, сэрэмжлүүлэг мэдээллээр хангах ажлыг эрчимжүүлэн зохион байгуулна.	2021 - 2024			Өвчлөлөөс сэргийлэх мэдээлэлийг иргэдэд тасралтгүй олон удаагийн давтамжтай цахим болон танхимаар өгч ажиллаж байна.	70%

1		3	4	5	6	7	8
4		1.1.4. Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, тусгаарлах болон эмчлэн тусгаарлах байруудын бэлэн байдлыг шуурхай хангаж эмч эмнэлгийн ажилтнуудыг халдвараас сэргийлэх арга барилд сургах ажлын байрны тасралтгүй сургалтыг тогтмол зохион байгуулж ур чадварыг нь дээшлүүлэн аюул эрсдлээс урьдчилан сэргийлж эрүүл мэндээр хохироохгүй байх арга хэмжээг авч ажиллана	2021 - 2024	-		Эрүүл мэндийн төв нь нийт ажилтан албан хаагчдаа эрсдэлээс сэргийлэх арга барилд сургасан	70%
2. Хоёр: Хүний хөгжлийн бодлогын хүрээнд:							
5		2.1.1. Төсөвт албан байгууллагуудыг ажлын байран дээрээ артерийн даралт, биеийн жингээ хэмжих, эрүүл мэндээ хамгаалахад зориулсан тоног төхөөрөмжийг бий болгон ажиллахад нь дэмжлэг үзүүлнэ.	2021 - 2024	-		Төсөвт байгууллагууд дээр даралт хэмжих нөхцөл ханган биеийн жингээ хэм хэмжээнд барих зөв зохистой хооллох талаар мэдээлэл сургалт 3 удаа хийгддэг	70%
6	2.1. “Эрүүл иргэн - Ирээдүйн үнэт зүйл”	2.1.2. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.	2021 - 2024	-		Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх сургалтыг зоотоог 2 удаа Эрүүл мэндийн газрын эмийн мэргэжилтэн Н.Амараа сургалтыг зохион байгуулсан нийт 16 ажилтанд. Эмийн сангийн эрхлэгч Х.Түвшинжаргал ард иргэдэд эмийн зохистой хэрэглээ, антибиотикийн зохистой хэрэглээ зэрэг сэдвүүдээр цахимаар болон ганцаарчилсан сургалтыг тогтмол зохион байгуулав.	90%

1		3	4	5	6	7	8
7		<p>2.1.3. Иргэдийн зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношлогоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулж, “Хавдрын эсрэг”, “Харшлаас сэргийлэх”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.</p>	2021 - 2024			<p>Иргэдийн дунд архи, тамхи, чихэрлэг хүнс хэрэглэхээс татгалзах хүслийг төрүүлэх мэдээлэл сургалт сурталчилгааг зорилтот бүлэгт чиглүүлэн 1 удаа хийж нийт 165 хүнийг хамруулж 5 хүн тамхинаас, 11 хүнийг архинаас гаргасан байна. Осол гэмтэл энэ онд 70 хувиар буурсан ба осол гэмтлээр нас баралт байхгүй. Эрүүл орчинтой ажлын байрыг дэмжин байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтанууд жилийн эцсийн байдлаар ард иргэдээс 18-аас дээш насны 650 иргэн нийт 1750 хүний цусны даралт, ихсэх, чихрийн шижингийн хэв шинж-2, бөөр, хөх умайн хүзүү, элэг ходоодны хавдар зэрэг өвчнийг эрт илрүүлэх үзлэгт хамруулж өвчлөлийг илрүүлж 2-р шатлалд шилжүүлэн ажилласан. Хөдөлмөрийн чадвар түр алдалт, мэргэжлээс шалтгаалах өвчлөл, тэдгээрийн шалтгааныг эрт илрүүлэх, бүртгэх, тандах, мэдээлэх арга хэмжээг хэрэгжүүлэн мэдээллийн сан үүсгэсэн.</p>	70%

1		3	4	5	6	7	8
8		2.1.4. Анхан шатлалд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн иргэдийн чирэгдлийг багасгана.	2021 - 2024	-		Анхан шатлалд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэн ажиллаж байна. Ард иргэдээс ирсэн гомдол байхгүй.	70%
9		2.1.5. Эрүүл мэндийн ажилтны ур чадварыг сайжруулж, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.	2021 - 2024	-		Ёс зүйтэй баг хамт олон болох зорилтыг тавин ажиллаж байгаа одоогийн байдлаар өргөдөл гомдол ирээгүй байна.	70%
10		2.1.6. Эрүүл шүд-Эрүүл хүүхэд хөтөлбөрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлж шүдний өвчлөлийг бууруулж үр дүнг тооцно.	2021 - 2024	-		Эрүүл шүд – Эрүүл хүүхэд хөтөлбөрийн хүрээнд урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулсан эрүүлжүүлэх арга хэмжээ хийгдээгүй	50%
11		2.1.7. Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөрийн хүрээнд иргэдийн зөв зохистой хоололтыг дэмжих сургалт сурталчилгааг тогтмол хийж хүн амын дундах хоол хүнсний далд чихэр тослогыг бууруулан эрсдэлт хүчин зүйлийн нөлөөллийг багасгах замаар илүүдэл жингээс сэргийлэх, бөөр зүрх судасны өвчлөлийг бууруулна.	2021 - 2024	-		Зөв зохистой хэрэглээ зөв хооллолтын сургалт сурталчилгааг 3 удаа хийгдсэн нийт 320 хүн хамрагдсан	70%

1	2	3	4	5	6	7	8
12	2.2. Эрүүл, идэвхитэй амьдралын хэв маягийг сурталчлах, эрүүл аж төрөх ёс, нийтийн биеийн тамирыг дэмжих үйл ажиллагааг орон нутгийн түвшинд дэмжин хөгжүүлнэ.	2.2.1. Иргэдэд бие бялдараа хөгжүүлэх спорт, спортын дасгал хөдөлгөөн, иог, бүжиг хийх зэрэг эрүүл, зөв амьдралын хэв маягийг хэвшүүлж, эерэг хандлагатай болгох нөлөөллийн үйл ажиллагааг бодлогоор дэмжин, төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, “Эрүүл, идэвхитэй амьдрал” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021 - 2024			Улсын хэмжээнд зохион байгуулж буй илүүдэл жингүй эртэч монгол идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих аяны хүрээнд Баянхонгор аймагт зохион байгуулагдаж буй “ЭРҮҮЛ ИРГЭН- ЭРТЭЧ БАЯНХОНГОРЧУУД” аянд сумын ЗДТГ –ын хамт олон болон 5 дугаар багийн иргэд нэгдсэн. Биеийн тамир спортын улсын хорооноос “Дасгал хөдөлгөөн хийцгээе” сарын аяны хүрээнд иргэдэд эрүүл зөв хооллолт, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, бие бялдараа хөгжүүлэх спорт, спортын дасгал хөдөлгөөн, иог, бүжиг хийх зэрэг эрүүл, зөв амьдралын хэв маягийг хэвшүүлж, эерэг хандлагатай болгох нөлөөллийн үйл ажиллагааг 10 хоног зохион байгуулсан. 10 хоногийн цогц сургалтанд нийт 4 эмэгтэй оролцсон.	70%

1		3	4	5	6	7	8
13		2.2.2. Суманд үйл ажиллагаа явуулж байгаа спорт заалны ашиглалтыг сайжруулж, нийтийн биеийн тамир, дасгал хөдөлгөөнийг хөгжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	2021 - 2024	-		Спорт заалаа түшиглэн иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, эрүүл чийрэг идэвхитэй хөдөлгөөнийг тогтмолжуулах зорилгоор фитнес танхимтай болсон. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд иргэд байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ажлын 5 өдөрт төрийн албан хаагчид /2 цаг 17-19/ бусад үед ард иргэдэд нээлттэйгээр тоглолтын хуваарь гарган хуваарийн дагуу үйлчилж байна.	90%
14		2.2.3. Спорт заалыг түшиглэн иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх эрүүл чийрэг идэвхитэй хөдөлгөөнийг тогтмолжуулах зорилгоор фитнес танхимтай болно.	2021 - 2024	7 сая байгууллагын төсөв		2021 онд төсвийн хөрөнгөөр 7000, сая төгрөгний фитнесийн тоног төхөөрөмж худалдан авч тустай өрөө тохижуулж, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.	100%
15	2.3. Хүн бүрт чанартай боловсрол эзэмшүүлж, боловсролын чанарын үнэлгээг дээшлүүлж,	2.3.1. Боловсролын байгууллагуудын хүүхдийн тоог нэмэгдүүлж хамран сургалтыг 80 хувьд хүргэнэ.	2021 - 2024	-		2020-2021 оны хичээлийн жилд 1-р ангид элсэн суралцагчдын хувь 51.7% байсан бол 2021-2022 оны хичээлийн жилд 1-р ангид элсэн сурагчдын хувь 65.1% болж өмнөх оноос 13.4%-иар өссөн.	90%

1	хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлнэ.	3	4	5	6	7	8
16		2.3.2. Орон нутагт дутагдалтай байгаа захиалгат мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудыг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулна.	2021 - 2024	-		Хөгжмийн багшаар мэргэжилгүй боловсролын байгууллагад багшаар 14 жил ажилласан, Соёлын төвийн эрхлэгчээр 7 жил ажилласан хүнийг авч ажиллуулж байна. Цаашид мэргэжил эзэмшүүлэхэд анхааран ажиллана.	70%
17		2.3.3. Уралдаан тэмцээнд амжилт гаргах	2021 - 2024	-		Боловсролын чанарын шинэчлэл-5” төслийг хэрэгжүүлэн 2190000 төгрөгөөр ухаалаг телевиз, мөн “Хүүхдэдээ тайлагная” өдөрлөгийг зохион байгуулж хүүхдийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэн 3 ангид 7 сая орчим төгрөгийн ухаалаг телевизийг Засаг даргын Тамгын газар, сургуулийн захиргаа, эцэг эхийн төлөөлөл шийдвэрлэж өгч нийт анги танхимын 70 гаруй хувь нь хосолсон сургалт зохион байгуулах нөөц боломжтой боллоо. Сурагчдын сурлагын хоцрогдол нөхөх, арилгах ажлын хүрээнд 7 хоногт давтлага 2 өдөр нь давтлага зохион байгуулж байна.	90%

1		3	4	5	6	7	8
18		2.3.4. Боловсролын чанарын үнэлгээг дээшлүүлж, суралцагчийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг хангасан бүтээлч багшийг бий болгож, “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлж шагнаж урамшуулна.	2021 - 2024	Байгууллагын төсөв		Глобаль дээд сургуульд багш С.Батчимэг, Ц.Пүрэвжаргал, Д.Ганболор нар суралцан боловсролын магистр зэрэг хамгаалж сургуулийн захиргааны зүгээс хүндэтгэл үзүүллээ. Нийт багшийн 31% нь магистр зэрэгтэй болов. “Боловсролын чанарын шинэчлэл-5” төслийн хүрээнд сурагчдын хоцрогдлыг нөхөх, арилгахад сайн туршлага түгээн ажиллаж байгаа багш С.Батчимэг, Ц.Пүрэвжаргал нарыг 150.0 төгрөг, өргөмжлөлөөр шагнав. Говийн бүсийн спортын наадамд баг хамт олноо бэлтгэн оролцуулж тэргүүн байр эзэлсэн багш Д.Эрдмаад ур чадварын 15%-ийн нэмэгдэл олгов. 1-р сурагчдыг 100% хугацаанд нь бичүүлж, уншуулж сургасан, 5, 9-р ангийн сурагчдыг амжилттай 100% төгсгөж байгаа багш Л.Болортунгалаг, Ц.Пүрэвжаргал, Т.Номин-Эрдэнэ нарт ур чадварын 10%-ийн нэмэгдэл олгов.	90%

1		3	4	5	6	7	8
19		2.3.5. Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын орчныг хүүхэд бүрд ээлтэй болгож багш нарын ур чадварыг нэмэгдүүлнэ.	2021 - 2024	-		Орчны аюулгүй байдалд байнгын хяналт үнэлгээ хийж, сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.. Багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааг тэдний хөгжих хэрэгцээг ханган нийт 2 удаагийн сургалт зохион байгуулсан.	70%
20		2.3.6. Насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, цахим, сургалтыг хөгжүүлж, иргэдийн тасралтгүй боловсролыг дээшлүүлнэ цахим сургалтын тоног төхөөрөмжөөр хангагдсан кабинеттэй болно.	2021 - 2024	-		Хүмүүжлийн эерэг аргын сургалтыг ехөнхий боловсролын сургуулийн багш ажилчид, хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилчдыг 100% хамруулан сургалтыг зохион байгуулсан. Мөн эцэг эхчүүд төрийн албан хаагчдад үе шаттайгаар сургалтыг зохион байгуулж ирсэн. Хүмүүжлийн эерэг арга сургалтын агуулга: 1. Хүүхдийг хүмүүжүүлэх Монгол уламжлал ба хүмүүжлийн эерэг арга 2. Хүмүүжлийн эерэг арга, түүний хэрэглээ 3. Багшийн харилцаа, ёс зүй, сайжруулах арга зам 4. Хүүхдэд сөрөг хэвшилтогтохоос урьдчилан сэргийлэх 5. Хүүхдийн насны онцлог	100%

1		3	4	5	6	7	8
21		2.3.7. Хөгжмийн кабинетийг тохижуулж хагжмийн зэмсгээр хангагдана.	2021 - 2024			Хөгжмийн кабинетын тохижилтод ханын самбар 6 ширхэгийг 300.0 төгрөгөөр хийлгэв. Соёлын төвөөс хөгжим техник хэрэгслийн тусламж авч морин хуур, гитар, ёочин хөгжмийн дугуйлан хичээллүүлж байна. Хөгжмийн зэмсгээр хангагдснаар хөгжмийн дугуйлангийн сурагчдын авьяасыг хөгжүүлж, зохиогдсон уралдаан тэмцээнд бэлтгэж, тэднийг урлагаар дамжуулан төлөвшүүлж сум орон нутгаас төрөн гарсан олон арван урлагийн алдартануудын залгамж халаа болгон бэлтгэнэ. Соёлын төвөөс үндэсний хөгжим 10, үүнд ёочин 3, ятга 3, морин хуур 4-ийг авч сургалтад ашиглаж байна. Эцэг эхчүүд хүүхдүүдээ дэмжин 13 гитар хөгжим авч өгөн гитарын дугуйлангийн сурагчид өөрсдөө хөгжимтэйгөө дугуйландаа ирдэг.	50%

1	2	3	4	5	6	7	8
22	2.4. Иргэдийн нийгмийн баталгааг хангах.	2.4.1. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд хамруулж, нийгмийн баталгааг хангана.	2021 - 2024	-		Сайн дурын даатгалд 176 даатгуулагч хамруулснаас шинээр 17 даатгуулагч хамруулсан. Хагас жилээр 96867,0 мянган төгрөгийг санд төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 100 хувь биелүүлсэн.	100%
23		2.4.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлнэ.	2021 - 2024			Сумын хэмжээний хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг гаргасан. Судалгаагаар 67 иргэн бүртгэгдсэн. Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамрагдсан иргэд байхгүй.	30%
24		2.4.3. Ажилтай орлоготой өрхийн тоог нэмэгдүүлж 100-аас доошгүй иргэн байнгын болон түр ажлын байраар хангагдана.	2021 - 2024	-		Хоршоог хөгжүүлэх сангийн төсөлд 3 хоршооны үйл ажиллагааг дэмжин 70,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож байнгын ажлын байр 15 гарч, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, амьжиргаанд нь тодорхой хэмжээний дэмжлэг үзүүллээ. Байнгын ажлын байр-8, түр ажлын байр-7	50%
25		2.4.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	2021 - 2024			Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 5 зорилт 12 заалтаар гарган хэрэгжүүлж байна. Төлөвлөөний биелэлт-50%	50%

1	3	4	5	6	7	8
26	2.4.5. Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	2021 - 2024			Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 5 өрхийн квотыг аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбар зөвлөл шийдвэрлэсэн. Малжуулах хөтөлбөрт хамрагдах шалгуур хангасан өрхийн судалгааг авч нэгтгэн, өрх сонгох ажлыг төлөвлөн ажиллаж байна. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 2 иргэний төслийг аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт хүргүүлсэн. Аймгийн салбар зөвлөл хуралдаагүй хүлээгдэж байна.	50%
27	2.4.6. Гэр бүлийн тогтвортой байдлыг хангаж, гэр бүлийн гишүүдэд ээлтэй бодлого хэрэгжүүлж хүний хөгжил, хамгааллыг сайжруулна.	2021 - 2024	-		Өрхийн хөгжлийг дэмжих аймгийн засаг даргын Захирамжаар 10 өрх сонгон хөгжлийн төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.	30%
28	2.4.7. Иргэдэд эрүүл аж төрөх дадал хэвшилд сургах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд хамруулна.	2021 - 2024	-		Тандалт судалгаагаар оролцогчдын 81,4% нь эрүүл дадал олж авсан үнэлгээтэй байна. Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг Баянхонгор политехник сургуульд үсчин, оёдол, гагнуур, сантехник,	70%

1		3	4	5	6	7	8
29		2.4.8. Ахмад өндөр настангуудын чөлөөлт цагаа өнгөрүүлэх, үйлдвэрлэл үйл ажиллагаа явуулах байртай болгож “Ахмадаа ачилъя” хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2021 - 2024			Ахмадуудад байртай болгож, сургуулийн хуучин дотуур байрны залыг хүлээлгэн өгсөн. Ашигласан байрын түрээс, халаалтын үнийг тооцохгүйгээр зохицуулсан. Хөтөлбөрийн хугацаа дууссан.	100%
30	2.5. Соёлын салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан иргэдийг соён гэгээрүүлж, биет болон биет бус өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, өсвөр үе залуучуудад сурталчлан таниулах, соёлын салбарын хүний нөөцийг чадавхижуулах.	2.5.1. Сумын нийт ард иргэдийн дунд соёл урлаг, спортын нэгдсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулна.	2021 - 2024			Хаврын баяр цэнгээнт бүжгийн 24 дахь уралдаанд 2 хамтлаг оролцож 1 хамтлаг нь мөнгөн медаль хүртсэн. Спорт заалаа түшиглэн иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, эрүүл чийрэг идэвхитэй хөдөлгөөнийг тогтмолжуулах зорилгоор фитнес танхимтай болсон. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд иргэд байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ажлын 5 өдөрт төрийн албан хаагчид /2 цаг 17-19/ бусад үед ард иргэдэд нээлттэйгээр тоглолтын хуваарь гарган , хуваарийн дагуу үйлчилж байна. Баянхонгор аймгаас зохион байгуулсан 7 төрөлт Ахмадуудын дунд 3 үе шаттай урлагийн арга хэмжэ	90%

1		3	4	5	6	7	8
31		2.5.2. Соёлын биет ба биет бус өв, түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, ард иргэдэд сурталчилан таниулна.	2021 - 2024			Орон нутгийн судлах танхимын хадгалалт хамгаалалтанд анхаарч стандартын шаарлага хангасан өрөөтэй болсон. Иргэдэд сурталчлан таниулж байна.	50%
32		2.5.3. Урлаг соёлын чанар хүртээмжийг нэмэгдүүлж ажиллана.	2021 - 2024			Шинээр соёлын ордонтой болж, 2021 онд 22 сая төгрөгний сандал ширээ тоног төхөөрөмж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж ая тухтай орчин бүрдэж соёлын арга хэмжээ тогтмол явагдаж иргэдэд соёлын үйлчилгээг үзүүлж байна.	70%
33		2.5.4. Иргэдийн ном унших дадал хэвшлийг нэмэгдүүлж сумын номын сангийн үйл ажиллагааг сайжруулна.	2021 - 2024			2022 онд номын сангийн фондыг нэмэгдүүлэхээр батлагдсан төсөвт багтааж ном худалдан авч номын санд баяжилт хийнэ. Уншигчидаас хүссэн номын судалгааг авч номыг захиалж ном сангийн фондыг нэмэгдүүлнэ.	30%

1	3	4	5	6	7	8
34	2.5.5. Соёл урлагийн салбарыг мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, тэдний ур чадварыг дээшлүүлнэ.	2021 - 2024	-		2022 оны 1-р сард бүжгийн багш, хөгжмийн багшийн авч ажиллуулж мэргэжлийн боловсон хүчнээр ханган ажилуулж байна. 2022.05.09 ны өдрөөс соёлын төвийн даргаар мэргэжлийн боловсон хүчин ирж ажилаа хүлээж авч соёлын төвийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.	70%
35	2.5.6. Түүх соёлын өвийг сүйтгэж байгаа хууль бус үйл ажиллагаатай хатуу тэмцэж, хариуцлагыг чангатгаж Соёлын өвийг хадгалан хамгаалж, өвлүүлэн, баяжуулан хөгжүүлж буй соёлын биет бус өв тээгч нарыг урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.	2021 - 2024			Зөрчил гараагүй	30%
36	2.5.7. Хоёр жилд 1 удаа соёл урлагийн өдрүүдийг суманд зохион байгуулж ардын авъяастнуудыг нийтэд сурталчилж, алдаршуулна.	2021 - 2024			Уг ажлыг 9-10 сарын хооронд зохион байгуулахаар төлөвлөж байна.	30%
37	2.5.8. Соёл урлагийн байгууллагын үйл ажиллагааг хөдөөд чиглүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж хувцас хэрэглэлээр хангана.	2021 - 2024	3 сая төгрөг- Байгууллагын төсөв		2022 оны төсөвт урлан уран бүтээлийн зардал 3,0 сая төгрөг төсөвлөгдөж ирсэн үүнээс 1700,0 төгрөг хөдөөгийн иргэд урлагийн тоглолт хийх, урлагын хувцас захиалахаар төлөвлөсөн . Одоогоор урлагийн хувцасны захиалга өгсөн. Массын 10 ширхэг хувцас, 3 ширхэг бүжгийн гутал, урлагийн дээл 1 тус тус захиалсан	50%

1	2	3	4	5	6	7	8
38		2.6.1. Гэр бүлийн боловсролыг бүх насны хүмүүст амьдралын мөчлөг, насны онцлогт тохирсон байдлаар олгоно.	2021 - 2024	300,000 төгрөг байгууллагын төсөвөөс		Хамтдаа төслийн хүрээнд аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран Өрх бүрт хүрч мэдээ мэдээллийг хүргэж ажилласан. Нийт өрхийн 53,6 % нь хамрагдсан.	90%
39	2.6. Гэр бүлийн тогтвортой байдлыг хангаж, гэр бүлийн гишүүдэд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүний хөгжил, хамгааллыг сайжруулна.	2.6.2. “Иргэний андгай өргөх” танхимтай болж шинээр гэрлэгсэд болон шинээр иргэний үнэмлэх гардаж буй иргэдэд хүндэтгэл үзүүлэх, гэр бүлд чиглэсэн сургалт сурталчилгаа явуулах.	2021 - 2024			Төлөвлөгөөт хугацаа болоогүй	100%
40		2.6.3. Залуучуудын сэтгэл зүй, хөгжил, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжсэн хөтөлбөрт арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021 - 2024			Залуучуудын хөгжлийг дэмжих салбар зөвлөлийг Засаг даргын захирамжаар байгуулан ажиллаж байна. Хөнгөлттэй нөхцлөөр их дээд сургуульд 1 оюутан суралцаж байна. Төрийн байгууллагуудад орон нутгаас 2 хүн шинээр ажилд томилогдсон байна. Санхүүжигдсэн хөтөлбөр байхгүй.	30%
41		2.6.4. Хүүхдийн хөдөлмөр зуслан байгуулж, хүүхдийг монгол ахуйд сургана.	2021 - 2024			Улиралын чанартай тул хэрэгжээгүй	0%

1		3	4	5	6	7	8
42		2.6.5. Угийн бичиг хөтлөлтийг үргэлжлүүлж, өрх бүр угийн бичиг хөтөлж, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлсэн байна.	2021 - 2024	-		Насан туршийн боловсролын нэгжээс Угийн бичиг хөтлөх ажлыг сумын бренд ажил болгож сонгон авч ажиллаж байна. 2021 оны байдлаар сумын нийт ард иргэдийн 24% угийн бичиг хөтлөж байгаа судалгаа гарсан. НӨУБ-ын 30 жилийн ойн хүрээнд нийт ард иргэдийн 30 хүртлэх хувийг угийн бичиг хөтөлүүлэх төлөвлөгөөт ажлыг эхлүүлэн ажиллаж байна.	30%
43		2.6.6. Сум орныхоо нэр хүндийг аймаг, улсад гаргаж байгаа залуучуудыг дэмжиж ажиллах, шагнаж урамшуулна.	2021 - 2024	Хандив тусламж, ЗД-ын нөөц хөрөнгө нийт-12сая төгрөг		Спортын мастер багш Д.Эрдмаагийн алдаршуулах волейболын тэмцээнийг шавь нарын санаачилгаар зохион байгуулж явуулсан. Азийн наадмын амжилттай оролцсон тамирчдыг сум орон нутгийн цахим хуудсаар алдаршууллаа.	100%

1		3	4	5	6	7	8
44		2.6.7. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, сумын эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг сайжруулж, үнийн өсөлтийг тогтвортой байлгана.	2021 - 2024	-		Сумын “Бадамлан асах жаргал” ХХК-ны эмийн эргэлтийн сангаас жилийн эцсийн байдлаар 218 нэр төрлийн 56 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авч ард иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байна хяналт шалгалтын явцад гарсан зөрчилгүй. Хяналт шалгалтын 4 удаа зохион байгуулаад байна. Одоогоор эмийн нөөцийн хангалт 90% - тай байна.	90%
45		2.6.8. Сумын хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлж гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлж ажиллана.	2021 - 2024	-		Хаагдсан кейсийг архивлаж аймгийн ГБХЗХГ-т албан тоотоор хүргүүлэв. 2022 онд 3 кейс нээсэн. 3 удаагийн сургалтаар 36 сурагч, 84 хүнд мэдээлэл хүргэлээ. Мөн богд сумын хамтарсан баг туршилга солилцох арга хэмжээг сум орон нутагт зохион байгуулж ажилласан.	70%
46		2.6.9. Иргэдийн бичиг баримтын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, бичиг баримтын үзлэг явуулах.	2021 - 2024			хэрэгжээгүй	0%

1		3	4	5	6	7	8
47		2.6.10. Сумын хүүхдийн зөвлөлийн ажлыг эрчимжүүлнэ.	2021 - 2024	1.5 сая төгрөг 3Д-ын нөөц		<p>“Бид хүүхдэдээ хүмүүжлийн эерэг аргаар нөлөөлөгч” аяны хүрээнд төрийн албан хаагчид, эцэг эх, сурагчдад Хүмүүжлийн эерэг аргын сургалтыг зохион байгуулж, хамт олны шийдвэрээр нэг ажилтан 11000 төгрөг ивээн тэтгэж Хүүхэд нэг бүрийг хамгаалах, хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 3 өрхийн 9 хүүхдэд 365000 төгрөгийн хүнсний тусламж олголоо. ГБХЗХГ, НҮБ-ын сангаас "Хамтдаа шийдье" төсөлт арга хэмжээний хүрээнд 2022 оны 04 сарын 17-18-ны өдрүүдэд Жинст сумд ЗДТГ, "Хамтарсан баг", хүмүүжлийн эерэг аргын сургагч багш Т.Бодьтөмөр, Ц.Дуламханд, дотуур байрын багш Э.Энхцэцэг нартай хамтарч Уубулан 1-р багт 59 айл өрх, Хүйс 2-р багт 71 айл өрх, Хөнөг 3-р багт 43 айл өрх, Цагаан-Ус 4-р багт 61 айл өрх, Бодь 5-р багт 111 айл өрхөөр орж нийт 345 иргэнд хүмүүжлийн эерэг аргын сургалтыг зохион байгуулж, материалыг тараалаа.</p>	100%

1	2	3	4	5	6	7	8
3. Гурав.Эдийн засгийн бодлого							
48	3.1. Санхүү эдийн засгийн хүндрэлийг тооцож, эдийн засгийг тогтвортой байлгахад анхаарах.	3.1.1. Татварын хууль тогтоомжийг сурталчилан хэрэгжилтэд хяналт тавих, улс орон нутгийн төсвийн орлогыг татварын нэр төрөл бүрээр жигд ханган биелүүлнэ.	2021 - 2024			Татварын багц хууль,болон ХХОАТ-ын тухай хуулийн тайлан гаргах талаар төрийн албан хаагчдад сургалт явуулж зааврыг танилцуулж цахим тайлангийн системд бүртгүүлэх, нууц үг аван нэвтэрч орох, тайлан илгаан талаарх сургалтыг төсөвт 6 байгууллагын албан хаагчдад байгуулага болгон дннр очиж явуулсан. 2022 онд Малын тоо толгойн хувь хэмжээг тогтоох саналыг нийт 186 малчнаас авсан. Иргэдийн Төлөөлөгчдлийн Хурлын 2022 оны 2 сарын 10-ны өдрийн хуралдаанаар хувь хэмжээгээр тогтоож 7/01 дугаар тогтоолыг Хууль Зүй Дотоод Хэргийн яаманд хүргүүлж улсын нэгдсэн бүртгэлийн 5729 дугаарт бүртгэгдсэн болно. Татварын орлого 04 сарын байдлаар нийт орлого 40320.0 мянган төгрөг орохоос 56539.0 мянган төгрөг орж 140.36 %, улсын төсвийн орлого 1470.0 мянган төгрөг орохоос 1937.2 мянган төгрөг орж 131.7 %,	100%

1		3	4	5	6	7	8
49		3.1.2. Татвар төлөгчдийн бүртгэл мэдээллийн зөрүүг арилган бүртгэлд хамрагдаагүй татвар төлөгчдийг бүрэн хамруулна.	2021 - 2024			Сумын 562 малчны шинэчилсэн мэдээллийг сумын Статистикийн албанаас авсан. Сумд бүртгэлтэй 28 аж ахуйн мэдээллийг шинэчилсэн болно.Галт зэвсгийн бүртгэл давхардсан, 1 иргэн 2 өөр зегистрийн дугаараар бүртгэгдсэн, тус сумын харъчат биш хүн бүртгэсэн зэрэг зөрчлүүд байсныг сумын цагдаа Даваацэрэнтэй хамтран цэгцэлсэн. Автотехникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн албан татвар хураах ажлыг Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсгийг сумын Засаг даргын захирамжаар байгуулсан. Техникийн үзлэг тооллого 5 сарын 25-26-ны өдрүүдэд явагдаж, энэ үеэр аймгийн Авто тээврийн газрын бүртгэл хариуцсан байцаагч Ган*Өлзий ирж сүүлийн 4-5 жилийн хугацаанд техник хяналтын үзлэгт хамрагдаагүй, татвар хураамж төлөөгүй, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, 25 автотээврийн хэрэгслийн	90%

1	3	4	5	6	7	8
50	3.1.3. Мэдээ, мэдээллийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны болон худалдан авах ажиллагааны цахим хэрэглээг иргэдэд сурталчлан таниулж, “Тунгалаг санхүү” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2021 - 2024			Төсвийн байгууллагуудыг санхүүгийн мэдээ мэдээллийн ил тод байдлыг цахим мэдээллийн санд хуулийн хуугацаанд нь бүрэн байршуулан ажиллаж байна	100%
51	3.1.4. Байгууллагуудын санхүүгийн сахилга батыг сайжруулж, ажилчдыг чадавхижуулан стандартын шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангана.	2021 - 2024	-		Хөдөө аж ахуйн тасаг, Бичиг хэргийн ажилтан, Төсөв төрийн сангийн мэргэжилтэн, Татварын байцаагч, Улсын бүртгэгч нарт компьютер техник хэрэгсэлээр бүрэн хангасан.	100%
52	3.1.5. Төрийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулан хяналт тавина.	2021 - 2024	-		ЗДТГазар орон сууцны 2 барилга Соёлын төвийн Хуучин барилга зэрэг ашиглалтгүй барилга байгууламжийг орон нутгийн өмчийн албаар шийдвэр гаргуулан дуудлага худалдаанд оруулж данснаас хассан.	100%
53	3.1.6. Гадаадын хөрөнгө оруулалттай төсөл хөтөлбөрүүдийг судалж гадаад харилцааг идэвхижүүлэн оновчтой хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.	2021 - 2024			Хэрэгжээгүй	0%

1		3	4	5	6	7	8
54		3.1.7. Төсөвт байгууллагуудын дансанд бүртгэлтэй тээврийн хэрэгсэлийн ашиглалт хамгаалалттай холбоотой зөрчлийг арилгана.	2021 - 2024	Орон нутгийн төсвөөс- 2сая төгрөг		Цагдаагийн тасгийн унааны засварт 4 сая төгрөгийг ЗД-ын нөөц хөрөнгөнөөс шийдэж 2022 онд Орон нутгийн төсөвөөс 2,0 сая төгрөг шийдэж засварт нийт 6,0 сая төгрөгийг шийдэж өгсөн.	90%
55		3.1.8. Бүртгэлээр тавих хяналтыг нэмэгдүүлэх, Өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулж, коджуулна.	2021 - 2024	-		Төсөвт байгууллагуудын хөрөнгийг цахим системд оруулж Төрийн болон ..орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.	50%
56		3.1.9. Төрийн байгууллагуудын автомашины парк шинэчлэлтийг хийх. Эрүүл хөрс-Эрүүл хүнс	2021 - 2024	Аймгийн төсөв		Сумын ИТХ-ын байгууллага LEXUS-470 маркийн автомашинтай болсон.	100%
57	3.2. Газар тариалангийн салбарын үйл ажилагааг дэмжиж, тариалалт, ургац хураалтыг нэмэгдүүлнэ.	3.2.1. Төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлын үр дүнг тооцох.	2021 - 2024	-		2021 онд 2 га-д төмс, 1,9 га-д хүнсний ногоо тариалж 1,9 тн төмс, 2,2 тн хүнсний ногоо хураан авсан. Тариалан эрхлэгч 10 өрхөд нарийн ногооны үрийн багц олгосон. 2022 онд 10% нэмэгдүүлнэ.	30%
58		3.2.2. Газар тариалан эрхлэгчдийг дэмжих, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, хүлэмж, зорь нэмэгдүүлэхэд зээлийн бодлогоор дэмжнэ.	2021 - 2024			Өрхийн тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор хүлэмжийн тариалан эрхлэгчдийг дэмжих аймгийн хөдөө аж ахуйн газраар дамжуулан хүлэмжийн	30%

1		3	4	5	6	7	8
59		3.2.3. Стандартын шаардлага хангасан зоорь, агуулах ашиглалтанд оруулна.	2021 - 2024			Төлөвлөгөөт хугацаа болоогүй	100%
60		3.2.4. Бэлчээр ашиглалтыг зөв зохион байгуулж, малын тэжээлийн ургамал тариална.	2021 - 2024			Сумаас аймгийн хурлын төлөөгчөөр сонгогдсон Д.Батбаярын санаачилагаар 50 га газарт малын тэжээлийн ургамал тариалах төлөвлөгөөтэй байна.	30%
61		3.2.5. Худаг уст цэг гаргах, шаардлагатай цэгүүдэд уст цэгийн хайгуул хийх.	2021 - 2024	ОНХС-20 сая төгрөг, Улсын төсвийн-25 сая төгрөгөөр		2022 онд улсын төсвөөр гүн өрмийн худаг нэг, малын тоо толгой албан татварын орлогоос худаг сэргээн засварлахад 20 сая төгрөг төлөвлөсөн.	50%
62	3.3. Үйлдвэржилтийн бодлогын судалгаан дээр	3.3.1. Үйлдвэржилтийн бодлоготой уялдуулж орон нутгийн чиглэлийг тодорхойлж хоршоо, нөхөрлөлд зээл олгож ажлын байрыг нэмэгдүүлнэ.	2021 - 2024			2022. 05.11 ны өдөр 3 хоршоонд хоршоо хөгжүүлэх сангаас 70 сая төгрөгийн зээл олгосон	30%
63	үндэслэн сумын үйлдвэржилтийн бодлогыг	3.3.2. Арьс шир, нэхий боловсруулах анхан шатны цехийн үйл ажиллагааг сайжруулан ажиллуулна.	2021 - 2024			2022 онд эсгийний үйлдвэр, нэхий элдэх цех ажилуулж байна.	70%
64	тодорхойлж зах зээлийг судлах, цаашид эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх.	3.3.3. Хог хаягдлыг боловруулах жижиг цех байгуулна.	2021 - 2024			Төлөвлөгөөт хугацаа болоогүй	100%

1	2	3	4	5	6	7	8
65	3.4. Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулж, малын чанар ашиг шимийг дээшлүүлэх	3.4.1. Малыг халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх, үйл ажиллагааг хэрэгжүүлж эрүүл бүс статусаа бататгана.	2021 - 2024			Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд улсын төсвөөс санхүүжүүлдэг вакцинд 18,400 тоо толгой мал сүрэг, орон нутгаас санхүүжүүлдэг вакцинд 12,600 тоо толгой, мал сүрэг, малчнаас санхүүжүүлдэг вакцинд 38,600, тоо толгой мал сүргийн бүрэн хамруулахаар мал эмнэлгийн нэгдсэн системт төлөвлөн сумын Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 29 өдрийн А/25 дугаар захирамжийн дагуу мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд мал эмнэлгийн дархлаажуулалтыг графикт хугацаанд хийж гүйцэтгэж байна. Мал амьтны гоц халдварт шүлхийн өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 1526 толгой үхэр сүргийг хамрууруулахаар төлөвлөснөөс 1199 толгой үхэр сүргийг дархлаажуулалтанд хамруулалаа. Өөр аймгийн нутаг дэвсгэр нутаглаж байгаа 244 толгой үхрийг дархлаажуулсан.	70%

1	3	4	5	6	7	8
66	3.4.2. Малын шилжилт хөдөлгөөн болон малын гаралтай бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулна.	2021 - 2024			Аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/21 дугаар захирамж, сумын засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 26 өдрийн А/47 Захирамжийн дагуу малын шилжилт хөдөлгөөнийг аймаг сумын хэмжээнд бүрэн хориглоно ажиллаж байна. Аймаг сумын Засаг даргын Захирамжийг зөрчсөн малчин, мал бүхий иргэдийг холбогдох газар хүлээлгэн өгөөд байна.	70%
67	3.4.3. Мал эмнэлгийн бэлэн байдлыг хангах, шаардлагатай эм бэлдмэлийн нөөц бүрдүүлнэ.	2021 - 2024			Малын эмийн санд бүртгэгдсэн чанарын шаардлага хангасан ариутгал халдваргүйжүүлэлтын бодисын нөөцийг бүрдүүлэх талаар судалгааг гаргаж, үнэ тарифыг судлан нөөц бүрдүүлэх талаар ажиллаж байна.	50%
68	3.4.4. Мал эмнэлгийн аж ахуйн нэгжийн үйлчилгээнд хяналт тавьж чанар хүртээмжийг нэмэгдүүлэх	2021 - 2024			Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг шалгах нэгдсэн хүснэгтийн дагуу шалгаж нэгдсэн системд шивэлт хийж ажилласан.	90%

1		3	4	5	6	7	8
69		3.4.5. Малын паразит болон бусад өвчлөлөөс сэргийлэх угаалгын стандартын ванныг нэмэгдүүлэх.	2021 - 2024	20 сая төгрөг-ОНХС		ОНХСангаас 2-р багт мал эмнэлгийн угаалгын ванныг барихаар гэрээг байгуулаад байна.	30%
70	3.5. Тогтвортой хөдөө аж ахуй	3.5.1. Малын чанар, ашиг шимийг сайжруулах малын тоог чанарт шилжүүлж “Монгол малчин” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2021 - 2024	5 сая төгрөг-ОНХС		5.000.000 төгрөгөөр 5 багийн 10 малчин өрх сонгон авч нийт 2000 малыг үзлэг ангилалтад хамруулах ажлыг эхлүүлж байна. Үүнээс 2.980.000 төгрөгөөр 2000 малын ээмэг Хүнс Хөдөө аж ахуйн яамнаас хэвлүүлэн авч ээмэглэн бүртгэлжүүлэн ажиллаж байна. Мөн 6.500.000 төгрөгөөр “Идрэн Залаа Жинст”-ийн 40 цагаан зусаг ямаагаар хээлтэгч, хээлтүүлэгч нь 100% бүрдсэн цөм сүрэг бүрдүүлэх ажлын 07 сард зохион байгуулна.	30%
71		3.5.2. Бэлчээр ашиглалт хамгаалалтыг сайжруулж, өнжөөж чөлөөлөх, усжуулах, бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	2021 - 2024			Сумын нутаг дэвсгэрт үлийн огтоны илэрц байхгүй.	90%
72		3.5.4. Сумын аюулгүй нөөцийн өвс тэжээлийг жил бүр зохих түвшинд бэлтгэнэ.	2021 - 2024	4,8 сая төгрөг-ОНХС		2022 онд 4,821,400 төгрөг ОНХС-нд суулгасан байгаа. 2022-2023 оны өвөл, хаврын бэлтгэл хангах төлөвлөгөө гарган ажиллаж байна.	30%
73		3.5.5. Орон нутагт хадлангийн талбайг усжуулж, хайс хамгаалалтыг хийнэ.	2021 - 2024			Төлөвлөгөөт хугацаа болоогүй	100%

1		3	4	5	6	7	8
74		3.5.6. Малчин өрхүүдийн малын им тамгийг бүртгэлжүүлж албан ёсны сударгаатай болно.	2021 - 2024	-		Хөдөө аж ахуйн тасаг, багийн Засаг дарга нар, сумын цагдаагийн хэсэг хамтран ажлын хэсэг байгуулан сумын хэмжээний бод малын им тамгыг бүртгэлжүүлж албан ёсны судалгаатай болно	30%
75		3.5.7. Шилмэл хээлтүүлэгчийн тоог нэмэгдүүлнэ.	2021 - 2024	-		2021 онд “Говь ХХК” Идрэн Залаа Жинстийн 22 цагаан ухна сумын “Мөнгөн сүрэг” үржлийн аж ахуй нэгжид худалдан авч өгсөн. Мөн энэ жил гэрээгээр ухна авсан өрхүүдээс 15 ухна ишиг сонгон авч хээлтүүлэгч малын тоог нэмэгдүүлнэ.	30%
4. Дөрөв. Байгаль орчин, ногоон хөгжил, газрын харилцааны бодлогын хүрээнд:							
76	4.1. Байгаль орчныг хамгаалах байгальд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх,	4.1.1. Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс урьдчилан сэргийлнэ.	2021 - 2024			Хөрсний шинжилгээ санхүүгийн бэрхшээлээс болж хийгдээгүй.	0%

1	байгаль орчны бодлогыг төлөвлөн хэрэгжүүлнэ.	3	4	5	6	7	8
77		4.1.2. Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчилан таниулж стандарт хэм хэмжээг мөрдүүлнэ.	2021 - 2024	Байгууллагын төсөв-300,000 төгрөг		Байгаль орчныг хамгаалах тухай, Усны тухай, Ойн тухай, Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Амьтны тухай хуулиудаар байгаль хамгаалагч нартай 6 ш гарын авлага бэлтгэн тарааж онлайнаар мэдээлэл хийсэн. Хамрагдсан хүний тоо - Мөн “Мазаалай хамгаалах өдөр”, “Дэлхийн усны өдөр”, Амьтан ургамал хамгаалах өдөр” “Цаг уурын өдөр”, Бүх нийтээр мод тарих өдөр” зэрэг байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг сурагчид, ард иргэдэд сурталчлан таниулах, байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулж байна. Бодь, Уубулан, Хөнөг багийн группээр сурталчилсан. Байгаль орчны багц хуулиудаас 3 төрлийн 500 ш гарын авлага материал хийж тараасан байна.	70%

1		3	4	5	6	7	8
78		4.1.3. “Хоггүй Жинст” аяныг зохион байгуулж хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх хог хаягдлыг дахин боловсруулалтын үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлнэ.	2021 - 2024	-		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулан сумын Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Жил бүр зохион байгуулагддаг “Цэвэр орчин-тохижилт” аяныг зохион байгуулан ажиллаж байна.	70%
79		4.1.4. Орон нутаг өөрийн нөөцөд тулгуурлан сумын төвийн ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлнэ.	2021 - 2024	ОНХС-10 сая төгрөг		Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн хэрэгжилтийг хангах зорилгоор сумын ойн зурваст “Хонгорын шугуй”ХХК-тай хамтран 30000 мод /улиас, хайлаас, бургас/-ны үрсэлгээ хийхээр бэлтгэл ажлыг хангаад байна. Мөн айл өрх өмчлөлийн газартаа ногоон байгууламжийн тоог тодорхой хувиар нэмэгдүүлэхээр 500 модны тарьц, суулгац захиалсан болно.	50%
80		4.1.5. Булгийн эхийг хамгаалах ундаргыг сэргээх ажлыг иргэд, малчид, нөхөрлөлийн оролцоотойгоор хийж хэрэгжүүлнэ.	2021 - 2024			Бодь 5-р багийн нутаг дэвсгэр болох Оготнотой булаг”-ийн хашсан хашааг сэргээн засварлаж, Хүйс 2-р багийн Зүүн задгайн булгийн эхийг хашиж хамгаалсан байна.	100%

1		3	4	5	6	7	8
81		4.1.6. Зэрлэг амьтадыг хамгаалах, өвс тэжээлийн хомсдлоос урьдчилан сэргийлэх, амьдрах орчныг сайжруулах чиглэлээр зэрлэг амьтны байршил бүхий газруудад биотехникийн арга хэмжээ авна.	2021 - 2024			Энэ жил харьцангуй цаг хүндрээгүй тул зэрлэг ан амьтанд биотехникийн арга хэмжээ аваагүй байна.	30%
82		4.1.7. Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хяналтыг сайжруулна.	2021 - 2024			Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг эрсдэл бүхий газруудад 2 удаа хийсэн, зөрчил илрээгүй байна. Хувиараа алт олборлогчдын тоо 100% буурсан байна.	90%
83		4.1.8. Ундны ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулна.	2021 - 2024			1. Сумын усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулж дэглэм зөрчигдөөгүй болно. 2. Улиатайн аманд аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулснаас эрүүл ахуйн бүсийн дэглэм алдагдаж байна. Цаашид Их Богдын байгалийн цогцолборт газартай хамтран хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлнэ. 3. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас нарийвчилсан үнэлгээ хийгдээгүй болно.	30%

1		3	4	5	6	7	8
84		4.1.9. Тахилгат уул, ус, газар нутгийн мэдээллийн санг бүрдүүлж, тахин шүтэх ёсыг түгээн дэлгэрүүлнэ.	2021 - 2024			Хэрэгжээгүй	0%
85		4.1.10. Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэдэд хүү багатай, хөнгөлөлттэй зээлд хамруулж дэмжлэг үзүүлнэ.	2021 - 2024			Хэрэгжээгүй	0%
86		4.1.11. Аймгийн аялал жуулчлалын сүлжээнд орсон Хавцгайтын хөндий, таван элс хоёр улиас зэрэг газруудад жуулчид дайран өнгөрүүлэх зорилгоор жуулчны гэр бааз барих, тохижуулах ажлыг шат дараатай хийнэ.	2021 - 2024			Хэрэгжээгүй	0%
87	4.2. Газрын харилцаа	4.2.1. Сумын хилийн цэсийн маргаантай газраар аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай хамтран ажлын хэсэг гарган хилийн тодруулалтын ажлыг зохион байгуулах, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлнэ.	2021 - 2024			Сумын хилийн цэсийн тодруулалтын ажлыг 2021 онд ажлын хэсэг байгуулан аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газартай хамтран хил залгаа Өлзийт сум, Баяновоо сум, Баацагаан сумуудтай хилийн цэсийн тодруулалтын ажлыг хийсэн.2022 онд ажлын хэсгийг байгуулан хил залгаа Баянговь сумтай хилийн цэсийн тодруулалтын ажлыг хийхээр явах газрын маршрут, газруудын судалгааг гаргаад байна.Хилийн цэсийн тодруулалтын ажлыг 06,07 дугаар саруудад хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна.	50%

1		3	4	5	6	7	8
88		4.2.2. Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийлгэнэ.	2021 - 2024	30 сая- ОХНС		Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 29.0 сая төгрөгийн өртөгтөйгээр Говь-Эко ХХК-р гүйцэтгүүлэн төлөвлөгөөг сумын ИТХ-ын хуралдааны 6/37 дугаар тогтоолоор батлуулан, төлөвлөгөөг тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
89		4.2.3. 1:100000 нутаг дэвсгэрт хаягжуулалынажлыг хийнэ. (улс, орон нутгийн чанартай автозам, аялал жуулчлалын газар, Тусгай хамгаалалттай газар, өвөлжөө, хаваржаа, тариалангийн талбай, уул уурхай)	2021 - 2024			Хаягжуулалтын тухай хууль, журамд нийцсэн стандартын дагуу 1:100000 нутаг дэвсгэрт хаягжуулалын ажлыг хийлгэхээр төлөвлөөд байна. Хаягжуулалтын ажил хийгдэхээр хүлээгдэж байна.	30%
5. Тав. Засаглалын бодлогын хүрээнд:							
90	5.1. Төрийн албыг түргэн шуурхай болгож, иргэдийг төрийн нэгдсэн бодлого, удирдлагаар хангаж,	5.1.1. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	2021 - 2024	-		Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах заавар журмуудыг хяналтанд авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төрийн албан хаагчдын ажлыг үнэлэхдээ журамд заасан үзүүлэлтүүдийг шалгуур болгон үйлчлүүлэгчдээс ирсэн гомдол саналыг хүлээн	70%

1	төрийн үйлчилгээг шуурхай хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх, нөхцөлийг бүрдүүлж, төрийн албанд ёс зүй, чадахуйн зарчмыг төлөвшүүлж, үйл ажиллагааны чанар хүртээмж, ил тод байдлыг сайжруулах.	3	4	5	6	7	8
91		5.1.2. Чадварлаг, хариуцлага, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлнэ.	2021 - 2024	-		Төрийн жинхэнэ албан хаагчдыг хуулийн дагуу томилгоожуулан аймгийн төрийн албаны зөвлөлтэй зөвшилцөн томилон ажиллуулж байна. Үйлчилгээний албан хаагчдыг сонгон шалгаруулалтаар томилохдоо тогтвор суурьшилтай ажиллах талаар байгууллагын удирдлагын зүгээс шалгуур тавин ажиллаж байна.	70%
92		5.1.3. Төрийн үйлчилгээний операторын үйл ажиллагааг эрчимжүүлж, төрийн байгууллагын үйл ажиллагаанд мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэт технологи, инновац нэвтрүүлэх замаар төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлж, бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ.	2021 - 2024	-		2021 онд Операторийн үйлчилгээг нийт 32 иргэнд лавлагаа гаргаж өгсөн бол 2022 эхний улирлын байдлаар 36 иргэнд лавлагаа гаргаж өгсөн байна.	100%
93		5.1.4. Авилга ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэн бүх нийтийн хандлагыг өөрчилнө.	2021 - 2024	-		влига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн албан хаагчдыг аймгийн хууль зүйн хэлтсээс зохион байгуулсан цахим сургалтанд хамруулсан. 3 удаагийн сургалтад 52 албан хаагч хамрагдсан байна. Авлига, ашиг сонирхлоос ангид байх талаар цахим мэдээллийг албан хаагчид, иргэдэд	70%

1		3	4	5	6	7	8
94		5.1.5. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлж иргэдэд эрх зүйн харилцаанд бие даан оролцох чадварыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	2021 - 2024	-		Сургалт арга хэмжээ, хэлэлцүүлгийг цахимаар зохион байгуулж байна. Төрийн албаны тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудаар гарын авлага материал 200 ширхэгийг бэлтгэн тараасан. Эрх зүйн хөтөчийн ажиллах журмын дагуу иргэдэд мэдээлэл хүргэн ажилласныг бүртгэх маягыг хөтлөн бүртгэлжүүлэн ажилласан. Хууль эрх зүйн зөвлөгөөг сумын хэмжээнд 300 гаруй иргэнд давхардсан тоогоор өгсөн байна. Цахим сургалт 2 удаа хийгдэж 86 албан хаагчид бүрэн хамрагдсан.	70%
95		5.1.6. Төрийн албаны мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, хүний нөөцийг чадавхижуулна.	2021 - 2024	-		Малын эмчээр суралцаж байгаа оюутны төлбөрт 500.0 мянган төгрөгийн төлбөрийг төлсөн. Төгсөөд сум орон нутагтаа ажиллана.	70%
96		5.1.7. Төрийн байгууллагын дотоод дэг журам, албан хаагчдын ажлын уялдаа холбоо, ажлын чанарыг сайжруулна.	2021 - 2024	-		Төсөвт байгууллагууд дотоод журам, хамтын гэрээндээ өөрчлөлт хийж хууль, журамд нийцсэн ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж байна	70%

1		3	4	5	6	7	8
97		5.1.8. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэн, мэргэжилтэй боловсон хүчнээр хангаж, архивын баримтыг цахим санд шилжүүлж, хадгалалт аюулгүй байдлыг сайжруулна.	2021 - 2024	-		Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Сургууль архив, бичиг хэргийн эрхлэгчийг орон тоогоор ажиллуулж байна. Нийт 2 удаагийн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсан. 2019 оны баримтыг цахимаар аймгийн архивт 6 байгууллага хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна..	50%
98		5.1.9. Багийн төвүүдийг ээлж дараатай тохижуулж, засвар үйлчилгээ хийнэ.	2021 - 2024	ОНХС-10 сая төгрөг		Хөнөг 3 дугаар багийн төв, Хүйс 2 дугаар багийн төвүүдийг засварлах ажил хийгдэж байна	90%
99	5.2. Иргэдийн амар тайван байдлыг хангах	5.2.1. Сумын хэмжээнд гарч буй гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцлийг тогтоон, урьдчилан сэргийлж хяналтыг сайжруулна.	2021 - 2024			Сумын Цагдаагийн байгууллагаас иргэдэд зориулан Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 87 төрийн албан хаагчдад зохион байгуулсан. Байгууллагын 34 багш, ажилтанд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиар сургалт зохион байгуулсан. Гэр бүлийн боловсрол олгох залуу гэр бүлийн сургалтад 6 гэр бүл, 2 өдрийн цахим сургалтад	50%

1		3	4	5	6	7	8
100		5.2.2. Малын хулгай гэмт хэргийн тоог бууруулахын тулд баг бүрт малчдын бүлгэмийг шинэчлэн байгуулаж үйл ажиллагааг эрчимжүүлж хамтран ажиллана.	2021 - 2024	-		Сумын хэмжээний 5 багийн малчдын бүлгэмийг шинэчлэн байгуулж бүлгэмээр дамжуулан сургалт сурталчилгааны ажлыг 5 багийн нийт 560 гаруй малчидад зохион байгуулж ажилласан. Мөн үр дүнтэй сайн ажилласан шилдэг малчдын бүлгэмийг сонгон шалгаруулж оны эцэст урамшуулахаар төлөвлөөд байна.	70%
101		5.2.3. Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр замын тэмдэг тэмдэглэгээ нэмэгдүүлнэ.	2021 - 2024			НӨУБ-ийн 30 жилийн ойн хүрээнд сумын хоринуудын дунд уралдаан зарлан осол гэмтлээс урьдчилан сэргийлэх тэмдэг тэмдэглэгээний тоог нэмэгдүүлэхээ ажиллаж байна.	50%
102		5.2.4. Сумын хэмжээний архины хамааралтай иргэдийг соён гэгээрүүлэх үүднээс “Жаргалтай амьдрал төв”-тэй хамтран ажиллана.	2021 - 2024			Сургалт сурталчилгааны ажлыг 1 удаа зохион байгуулж 5 хүн хамрагдсан. Сумын хэмжээний архины хамааралтай иргэдийн судалгааг гаргаж холбогдох газарлуу явуулсан.	70%

1		3	4	5	6	7	8
103		5.2.5. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж буй гэмт хэрэг зөрчлийн тоог бууруулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.	2021 - 2024			2022 онд гэр бүлийн хүчирхийллийн дуудлага ирээгүй. Мөн өмнөх онуудад гарсан гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл дээр кейс үүсгэн ажиллаж тодорхой үр дүнд хүрсэн тул үйлчлүүлэгчийн хүсэлтээр хааж, архивласан. аймгийн ГБХЗХГ-т 22 кейс хүлээлгэн өгсний 3 нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үүссэн кейс байна. Хүчирхийлэл гарч болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэн хамтарсан багаар урьдчилан сэргийлж ажиллаж байна.	70%
104		5.2.6. Согтуугаар болон хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоог бууруулж хяналтыг сайжруулна.	2021 - 2024			Сумын Засаг даргын захирамжаар 09:00-20:00 цаг хүртэл архи согтууруулах ундааг худалдан борлуулахыг зөвшөөрч бусад цагаар архи худалдан борлуулсан тохиолдолд зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ авч ажиллаж байна. Ингэснээр согтуугаар үйлдэгдэх гэмт хэргийн тоо буурсан.	70%

1		3	4	5	6	7	8
105		5.2.7. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	2021 - 2024	Засаг даргын нөөц		2021 онд Эрүүл мэндийн төвийн түргэн тусламжийн үйлчилгээнд явж байсан Пургон автомашиныг шилжүүлж өгсөн. Мөн Засаг даргын нөөц хөрөнгө 4.350,000 төгрөгөөр машинд засвар үйлчилгээ хийлгэж, тусгай хэрэгслээр хангасан. Засаг даргын Тамгын газрын хөрөнгөөр иж бүрэн шинэ компьютер авч өгсөн.	90%
106		5.2.8. Гудамж талбайн гэрэлтүүлэг, тохижилтыг хийж гүйцэтгэнэ.	2021 - 2024			Төлөвлөгөөт хугацаа болоогүй	0%
107		5.2.9. Сумын төвийн гудамж талбайг камержуулна.	2021 - 2024			Төлөвлөгөөт хугацаа болоогүй	0%
6. Зургаа. Орон нутгийн хөгжил							
108	6.1. Орон нутгийн хөгжил	6.1.1. Засаг даргын Тамгын газрын барилгыг шинээр барьж төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулна.	2021 - 2024			Хэрэгжээгүй	0%
109		6.1.2. Шинэ цэцэрлэг барьж ашиглалтанд оруулан хүүхэд багачууд тохилог орчинд сурч хүмүүжих нөхцөлийг бүрдүүлнэ.	2021 - 2024			хэрэгжээгүй	0%
110		6.1.3. Стадионд түшиглэн гүйлтийн зам, хөл бөмбөгийн талбай бүхий биеийн тамирын талбайг бий болгоно.	2021 - 2024	ОНХС		Нийтийн эзэмшлийн стадион засварыг ОНХС-ийн 7 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн.	90%

1	3	4	5	6	7	8
111	6.1.4. Сумын төв дунд 2 км шороон замыг асбальтон хучилттай зам болгож тоосжилтыг багасгана.	2021 - 2024			улиралын чанартай ажил эхлээгүй байна.	30%
112	6.1.5. Дулааны шугам сүлжээний өргөтгөлийг хийнэ.	2021 - 2024	ОНХС-40 сая		ОНХС-ийн хөрөнгөөр өргөтгөл хийгдэнэ ажил эхлээгүй байна.	30%
113	6.1.6. Улиатай амны усыг хуримтлуулж хөв байгуулна.	2021 - 2024			Төлөвлөгөөт хугацаа болоогүй хэрэгжээгүй	0%
114	6.1.7. Хогний машинтай болно.	2021 - 2024	ОНХС-ын төсвөөс 32.800,000 төгрөгөөр		Зориулалтын стандарт хогний машин худалдан авч бүрэн ажиллагаанд оруулсан байна.	100%
115	6.1.8. Сумын хэмжээнд брэнд бүтээгдэхүүнтэй болно.	2021 - 2024			Хэрэгжээгүй	0%
116	6.1.9. Зэргэлдээ аймаг, сумдуудтай шефийн холбоо тогтоож ажиллана.	2021 - 2024			Хэрэгжээгүй	0%
117	6.1.10. Эрчим хүчний өргөтгөл хийж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	2021 - 2024	ОНХС-65 сая		Энэ онд хийхээр төлөвлөгдсөн ажил эхлээгүй байна	50%
118	6.1.11. Скайтелийн 3G сүлжээг Хүйс, Хөнөг, Цагаан Ус багуудын өндөрлөг газарт байршуулна.	2021 - 2024			Хэрэгжээгүй	0%
119	6.1.12. Засаг даргын Тамгын газрын барилгыг их завсарт оруулсан байх.	2021 - 2024	АОНХС-300 гаруй сая		Аймгийн ОНХС-ийн төсвөөр их засварт энэ онд орохоор болсон ажил хараахан эхлээгүй байна.	30%
120	6.1.13. Бохирын машинтай болно	2021 - 2024			Төлөвлөгөөт хугацаа болоогүй хэрэгжээгүй	0%

1	2	3	4	5	6	7	8
121	6.1. Орон нутгийн хөгжил	6.1.14. Нэг гудамжийг жишиг гудамж болгох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	2021 - 2024			Улиралын чанартай ажил 6 сард өрнүүлэхээр төлөвлөөд байна	30%

ХЯНАСАН
ЗАСАГ ДАРГА

НЭГТГЭСЭН
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Р.БАТЖАРГАЛ

Н.СУМЪЯА